

**“МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК-ИЙН
НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 04 сарын 23 өдөр

Улаанбаатар хот

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04 дугаар сарын 23-ны өдөр 18:00 цагаас 19:50 цагийн хооронд Шангри -Ла зочид буудлын 1-р давхрын хурлын танхимд хуралдаж, хурлын ирц, санал хураалт, асуултыг www.investmentexpo.mn вэбсайтаар хураав.

Хурлын дарга: Өлзийбаярын ГАНЗОРИГ

Хурлын нарийн бичгийн дарга: Балдангийн ЭНХТҮВШИН

Тооллогын комисс: Г.Баасанбат /Комиссын дарга/

Гишүүд: Б.Болорзаяа

Э.Гүнбилэг

Саруулбуян

Хуралд оролцсон нэгж эрх эзэмшигч нарын тоо: 1,210

Хуралд оролцсон саналын эрхтэй нэгж эрх эзэмшигч нарын тоо: 28,661,150 ширхэг

Хурлын ирц: 57.33 хувь буюу олонх.

НЭГ. МЭДЭЭЛЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ны нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах шийдвэрийг 2022 оны 03 сарын 14-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаас шийдвэрлэсэн тухай мөн уг шийдвэрийн дагуу 2022 оны 03 сарын 17-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид нэгж эрх эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хүргүүлсэн тухай танилцуулав. Нэгж эрх эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 2022 оны 03 сарын 18-ны өдөр, 2022 оны 04 сарын 04-ны өдрүүдэд тус тус мэдээлснийг танилцуулав.

Хурлын зар болон хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хорооны 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу 2022 оны 03 сарын 18-ны өдрийн дотор брокер, дилерийн компаниудад цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргүүлж, нэгж эрх эзэмшигчдийн хурлын материалтай танилцах боломжоор хангаж ажилласан болохыг мэдэгдэв.

Мөн Нэгж эрх эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрийг 2022 оны 04 сарын 04-ны өдрөөр тогтоосныг танилцуулав. Тооллогын комиссын дарга Г.Баасанбат: Нэгж эрх эзэмшигчдийн хурлын ирц хураалтын аргачлал болон “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон Тооллогын комиссоос ирүүлсэн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн нэгж эрх эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах болсон шалтгаан, хуулийн үндэслэлийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав.

Нэгж эрх эзэмшигчдийн хурлын дарга Ө.Ганзориг нээлтийн үг хэлснээр хурал албан ёсоор эхлэв.

ХОЁР. ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1 дүгээр асуудал: Менежментийн компанийн итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан;

2 дугаар асуудал: Аудитлагдсан санхүүгийн тайлан;

3 дугаар асуудал: Кастодианд хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан;

4 дүгээр асуудал: Сангийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

5 дугаар асуудал: ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

6 дугаар асуудал: Сангийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

1 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Сангийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

Танилцуулсан: ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг.

Танилцуулгын гол агуулга: “Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС”-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, 2021 оны зорилго зорилтуудын гүйцэтгэлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан дүгнэлтийг хөрөнгө оруулагч та бүхэнд танилцуулж байна.

“Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС”-ийн ТУЗ нь 2021 оны 12 сарын 19-ны ТУЗ-ийн ээлжит хурлаар сангийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцсэн баталсан. ТУЗ-ийн баталсан 2022 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гол зорилго нь банкны IPO-д оролцох, хөрөнгө байршуулалтыг оновчтой хийх, сангийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг тогтворжуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх юм. 2021 онд Банкны IPO-той холбоотой хэлцэл хойшлогдсон хэдий ч 1,0 тэрбум төгрөгийн ашигтай (татвар төлсний дараа) ажиллаж, цэвэр активын үнэлгээ 51.0 тэрбум төгрөгт хүрлээ.

“Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС” нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 8 сарын 18-ны өдрийн 328 тоот тогтоолоор тусгай зөвшөөрөл авснаар Монголын хамгийн том хөрөнгө оруулалтын сан болсон. Энэ үйл явдал нь Монголын хөрөнгийг зах зээлийг идэвхжүүлэх, хөрөнгө оруулагчдыг чадавхжуулах, ард иргэдийн хөрөнгийн зах зээлд итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдол бүхий онцлох үйл явдал болсон. 2021 он хэдийгээр хүнд хэцүү жил байсан боловч “Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС” ХХК гүйцэтгэх удирдлагын баг төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж ТУЗ-өөс дүгнэж байгааг танилцуулав.

3 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан;

Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн менежер Г.Ганзориг

Танилцуулгын гол агуулга: 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон орлого үр дүнгийн тайланг танилцуулав. 2021 онд 1,0 тэрбум төгрөгийн ашигтай ажилсан бөгөөд нийт актив 51,0 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Нийт 49,6 тэрбум төгрөг хөрөнгө оруулалтын хэлбэрээр байгаа ба 427 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын хүүгийн авлагатай байна.

2 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн 2021 оны Менежментийн компанийн итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайланг танилцуулах;

Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн менежер Г.Ганзориг


Танилцуулгын гол агуулга:

Хөрөнгө оруулалтын бодлого: Сангийн хөрөнгө оруулалтын стратеги нь “income investing” буюу “тогтмол орлого” болон “growth investing” буюу “хөрөнгийг өсгөх” гэсэн хосолмол аргад суурилдаг. “Income investing” стратегийн хүрээнд хөрвөх чадвар сайтай үнэт цаасыг сонгон авч сангийн хөрвөх чадварыг хангадаг. “Growth investing” стратегийн хүрээнд өндөр өгөөжтэй байх үнэт цаасыг сонгон авч сангийн өсөлтийг хангадаг. Сан нь зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан эрсдэлийн зохих түвшинд, хамгийн өндөр өгөөж олох байдлаар багцыг бүрдүүлдэг ба хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн хүрээнд ажиллана. Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн дагуу багцын 70%-д банкны хувьцаанд хөрөнгө оруулах боловч банкны IPO хийгдэх хугацаа хойшлогдсон тул одоогоор хөрөнгө оруулалтын багц нь томоохон нээлттэй компаниудын хувьцаа болон тогтмол орлоготой үнэт цааснаас бүрдэж байна.


Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл: Хөрөнгө оруулалтын сангийн багцын гол бүрэлдэхүүн болох банкнуудын IPO харахан эхлээгүй тул Мандал Ассет Менежментийн зүгээс сангийн хөрөнгийг мөнгөний захын хэрэгсэл (хадгаламжийн хэрэгсэл), хөрөнгийн захын нээлттэй хэрэгслүүдэд (нээлттэй бонд, компанийн хувьцаа) байршуулсан.

2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1 тэрбум төгрөгийн ашигтай (татвар төлсний дараа) ажиллаж, цэвэр активын үнэлгээ 51 тэрбум төгрөгт хүрлээ.

Сангийн хөрөнгийн бүтэц:



Хөрөнгө оруулалтын багийн ангилал, хувь /2021/



Хувьцааны багц сектороор, хувь /2021/



3 ДУГААР АСУУДАЛ:

Кастодианд хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайланг танилцуулах;

Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн менежер Г.Ганзориг

Танилцуулгын гол агуулга:

2021 оны 06 сарын 16-ны өдөр Голомт банк болон Мандал Ассет Менежмент ҮЦК нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмын хүрээнд “Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээ” байгуулснаар Голомт Кастодиан банк нь “Мандал ирээдүйн өсөлт хамтын хаалттай ХОС”-д оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэж хадгалах, үнэт цаас худалдаж авахтай холбоотой төлбөр тооцоог гүйцэтгэх, хүүгийн болон ногдол ашиг цуглуулах, нэгж эрхийн тухайлсан бүртгэл хөтлөх, нэгж эрхийн цэвэр үнэлгээ тооцоолж олон нийтэд мэдээлэх зэрэг цогц үйлчилгээг үзүүлэх болсон.

Кастодиан үйл ажиллагааны жилийн тайлан

Голомт банкны кастодиан банкны хэлтэс нь Сантай байгуулсан “Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээ”-ний үндсэн дээр доорх үйл ажиллагааг Санд үзүүлж байна. Үүнд:

Хөрөнгө хадгалах үйлчилгээ

Голомт банкны кастодиан банк нь 2021 оны 12 сарын 31 байдлаар Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС ХХК-ийн 51.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг хадгалж байна.

Нэгж эрхийн тухайлсан бүртгэл

Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС ХХК нь Монголын Хөрөнгийн Биржээр нэгж эрхээ арилжаалдаг бөгөөд нэгж эрхийн төвлөрсөн бүртгэлийг Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр хийлгэдэг онцлогтой. Нэгэнт нээлттэй зах зээл дээр нэгж эрхээ арилжаалдаг тул Кастодиан банк нь ҮЦГХТ-тэй тусгайлан байгуулсан гэрээний үндсэн дээр нэгж эрхийн шинэ өмчлөгчдийн мэдээллийг өдөр тутам системээр холбогдон авч, тухайлсан бүртгэлийг өдөрт нь гүйцэтгэдэг. Нэгж эрхийн тухайлсан бүртгэлийн эцсийн мэдээллийг Мандал Ассет Менежмент ҮЦК-аас томилогдсон “Мандал ирээдүйн өсөлт хамтын хаалттай ХОС” ХХК-ийн менежерүүдэд тусгайлан олгосон эрхээр өөрийн системээр дамжуулж өдөр тутам мэдээлдэг болно.

Нэгж эрхийн цэвэр үнэлгээ

Кастодиан банк нь хөрөнгө оруулалтын сангийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг Хөрөнгө Оруулалтын Сангийн Тухай Хууль болон холбогдох дүрэм, журамд заасны дагуу өдөр бүр тооцоолж, Монголын Хөрөнгийн Биржийн вэбсайтаар дамжуулан олон нийтэд мэдээлж байна

4 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Сангийн 2021 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;

Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг

Танилцуулгын гол агуулга: Сангийн хөрөнгө оруулалтын үндсэн чиглэл нь системийн нөлөө бүхий банкны IPO-д оролцон, сангийн өгөөжийг нэмэгдүүлэх юм. 1 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, Цэвэр активын үнэлгээ 51 тэрбум төгрөгт хүрлээ.

2022 онд системийн банкнууд IPO хийснээр Сангийн хөрөнгө хуваарилалтын зорилго биелж, улмаар нэгж эрх эзэмшигчдэдээ өндөр өгөөж хүртээх боломж бүрдэх хүлээлт үүсээд байна.

Өнгөрч буй 2021 онд цар тахлын нөлөө бүрэн намжаагүй, зах зээл дэх хүү буурсан, бизнесийн орчинд тодорхой бус байдал давамгайлсан, системийн банкнуудын IPO тодорхой болоогүй, нэлээдгүй сорилттой жил болж өнгөрлөө. “Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОМ” ХХК-ийн менежментийн баг эдийн засгийн сорилттой энэ цаг үед тохирсон хөрөнгө оруулалтын стратеги баримтлан, хөрөнгө оруулалтын багцын хөрөнгийг өсгөн, амжилттай ажилсан гэж ТУЗ-өөс дүгнэж байгааг танилцуулав.

5 ДУГААР АСУУДАЛ:

Сангийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн менежер Г.Ганзориг

Танилцуулгын гол агуулга: 2022 оны 02-р сарын 16-ны өдрийн 22/001 тоот “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн тогтоолыг уншиж танилцуулав.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, “Мандал Ирээдүйн өсөлт” хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан (“ХОС” гэх)-ийн дүрмийн 10 дугаар зүйл 10.4.7 хэсгийг тус тус удирдлага болгон ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Мандал Ирээдүй Өсөлт” хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулалтын бодлогод заасны дагуу эдийн засгийн өсөлтийг хангах зорилгоор 2021 оны цэвэр ашгаас ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай тогтоол мэдэгдлийг ХОС-ийн нэгж эрх эзэмшигчид, олон нийт, эрх бүхий байгууллагад мэдэгдэх ажлыг зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ТУЗ-ийн тогтоолыг уншиж танилцуулав.

6 ДУГААР АСУУДАЛ:

Сангийн ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Сангийн ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр батлуулахаар Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна. Үүнд:

Сангийн ТУЗ-ийн хурлын зардал 2,0 сая төгрөг, Бичиг хэргийн зардал 1,0 сая төгрөг нийт 3,0 сая төгрөгийн төсвийг батлуулахаар танилцуулав.

Асуулт, Хариулт

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга асуулт хариулт эхэлснийг зарлаж тооллогын комиссын даргаас нэгж эрх эзэмшигч нараас ирсэн асуултуудыг авав. Цахим хэлбэрээр нэгж эрх эзэмшигчдээс асуулт авч байгаа бөгөөд, бүх нэгж эрх эзэмшигчдийн асуултад хариулах боломжгүй тул асуултуудыг агуулгын хувьд ижил болон олон давхацсан таван асуултуудад хариулахаар сонгосныг тайлбарлав.

Асуулт 1:

Аль банканд хөрөнгө оруулалт хийх вэ?

Хариулт: Сангийн менежер Г.Ганзориг:

Аливаа хөрөнгө оруулалтын хэлцэл гэдэг бол нууцын зэрэглэлтэй байдаг тийм болохоор хэлцэл амжилттай болдог. Тийм болохоор яг энэ банкныг бид авах гэж хэлэх нь зохимжгүй байна. Гол нь банкнууд маань IPO хийх хугацаа ойртсон байна. Бидний анхны зорьж байсан хөрөнгө оруулалт хийх хугацаа улам ойртсон байна гэсэн үг. Өмнөх жил банкнуудын үнэлгээ тооцоо тодорхой болоогүй байсан бол саяхнаас банкнуудын үнэлгээ нь тодорхой боллоо. Бид тодорхой хэдэн банкнуудаас судалгаа хийгээд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байгаа. Удахгүй нэгээс хоёр сарын дараа банзнууд IPO хийхэд бид аль нэг банканд хөрөнгө оруулалтаа хийх болно.

Асуулт 2:

Хөрөнгө оруулалтын сангийн ойрын 5 жилийн хугацаанд нэгж хувьцааны үнэ хэд хүрэх вэ? Тооцоолол бий юу?

Хариулт: Сангийн менежер Г.Ганзориг:

Бид 2 зүйлийг харах ёстой, нэгж эрхийн үнэ болон цэвэр хөрөнгийн үнэлгээ. Хамгийн гол үзүүлэлт нь цэвэр хөрөнгийн үнэлгээ юм. Цэвэр хөрөнгийн үнэлгээ гэдэг нь Сан дээр байгаа хөрөнгийн өсөлтийг илэрхийлж байдаг. Харин нэгж эрхийн үнэ бол хоёр хүний хоорондын тохирсон арилжааны үнэ байдаг. Цэвэр хөрөнгийн үнэлгээг Кастодиан банкаас тооцоолж гаргадаг. Нэгж эрхийн үнэ болон цэвэр хөрөнгийн үнэлгээг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаснаас харах боломжтой байдаг. Бид анх хөрөнгө оруулалтын санг байгуулахдаа жилд хамгийн багадаа 15%-ийн өгөөжтэй ажиллах бүрэн боломжтой юм байна гэж байгуулсан.

Өгөөжийн хувьд амлалт өгөх нь боломжгүй бөгөөд нэгж эрх эзэмшигч нарыг төөрөгдүүлэх, зах зээлд зохиомол эрэлт эсвэл нийлүүлэлт үүсэх эрсдэлтэй байдаг тул Санхүүгийн зохицуулах хорооноос өгөөжийн амлалт өгөхийг хориглодог.

Хариулт: ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг: Энэ асуулт над дээр маш их ирдэг тийм болохоор Г.Ганзориг захирлын хэлсэн дээр нэмээд тайлбар өгмөөр байна. Сангийн менежерийн хамгийн гол анхаарах зүйл юу вэ гэхээр та бидний мөнгийг бодитоор өсгөх тухай асуудал юм. Харин хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж байгаа ханш бидэнд бараг хамаагүй зүйл. Хамгийн чухал нь Сангийн хөрөнгө оруулалт нь бэлэн мөнгөөр байдаг, бид барилга, уул уурхайн лиценз авдаггүй. Одоогоор бид долоон гаруй мянгуулаа байгаа, энэ хүмүүс лундаас 10 жилийн хугацаанд сандаа байх боломжгүй гэнэт мөнгөний шаардлага гарсан тохиолдолд зарж байгаа. Энэ тохиолдолд ханш унаж байгаа. Бид нэгж эрхийн үнийг 5 жилийн дараа тэдэн төгрөгт хүргэнэ гэж амлаж болохгүй, амлаж чадахгүй, амлахгүй. Бидний ёс зүйд тийм юм байхгүй. Харин бид хөрөнгө оруулалтын сангийн мөнгийг өсгөх тал дээр анхаарч ажиллана.

Асуулт 3:

Хэрвээ банкнуудын хувьцааны тодорхой хэсгийг хөрөнгийн биржээр арилжих хугацааг хойшлуулбал сангийн зүгээс ямар салбарт хөрөнгө оруулах вэ? СЗХ-оос саяхан анхны нээлттэй, хамтын хөрөнгө оруулалтын санд зөвшөөрөл олголоо гэдэг нь манай сангаас ямар ялгаатай вэ?

Хариулт: Сангийн менежер Г.Ганзориг:

- Банкны IPO хэрэв хойшлуулбал гэж байна гэхдээ энэ хойшлогдохгүй байх. IPO гэдэг бол хэдэн сар жилийн өмнөөс бэлдэж хийдэг ажил байдаг. Банкнууд маань сүүлийн нэгж жилийн хугацаанд бэлтгэл ажлаа хийсэн аудит, үнэлгээ, хуулийн гээд зардлууд гаргасан, тийм учраас хойшлогдохгүй байх. Гэхдээ бараг боломжгүй буюу хойшлох тохиолдол гарвал бид хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтаа дахин хэлэлцээд шинэчлээд тухайн хөрөнгө оруулалтын бодлого доо хаашаа ямар хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх вэ гэдгээ тодорхой заагаад тэрнийхээ дагуу хөрөнгө оруулалт хийж ажиллана.
- Нээлттэй хөрөнгө оруулалтын сан манай хөрөнгө оруулалтын сангаас юугаараа ялгаатай вэ гэсэн асуулт байсан. Нээлттэй хөрөнгө оруулалтын сан гэдэг бол хөрөнгө оруулагч чөлөөтэй орж гардаг буюу сангийн хэмжээ өсөж буурч байдаг бол хаалттай сан бол хөрөнгийн хэмжээ байнга өсөж байдаг.

Асуулт 4:

Хөрөнгө оруулалтын багцад сан гадагшаа хөрөнгө оруулалт хийсэн байгаа юу?

Хариулт: Сангийн менежер Г.Ганзориг:

Бид анх хөрөнгийн оруулалтын сан байгуулахдаа хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтыг боловсруулж Санхүүгийн зохицуулах хороогоор батлуулсан. Тус журмаас гадуур хөрөнгө оруулалт хийх хориотой байдаг. Гадагшаа хийсэн хөрөнгө оруулалт гэвэл Монголын засгийн газрын гадаадын хөрөнгийн бирж дээр гаргасан бонд өрийн бичгийг бид авсан. Үүнээс өөрөөр гадаад зах зээлд оруулсан хөрөнгө оруулалт байхгүй байгаа.

САНАЛ ХУРААЛТ

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга Г.Баасанбат

Танилцуулгын гол агуулга: Санал хураалтын хуудас бөглөх зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

ХОС-ИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХАД АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлахад өгсөн саналын эрхтэй нэгж эрх эзэмшигчдийн 22,422,490 ширхэг хувьцааны санал буюу 96.51 хувийн саналаар 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.

“МАНДАЛ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК” ХХК-ИЙН ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН ТАЙЛАНГ БАТЛАХ ТУХАЙ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

“Мандал Ассет менежмент ҮЦК” ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээний 2021 оны жилийн тайланг батлахад өгсөн саналын эрхтэй нэгж эрх эзэмшигчдийн 22,470,200 ширхэг нэгж эрхийн санал буюу 99.05 хувийн саналаар батлав.

КАСТОДИАНЫ ХӨРӨНГӨ ХАДГАЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛИЙН ТАЙЛАНГ БАТЛАХ ТУХАЙ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайланг батлахад өгсөн саналын эрхтэй нэгж эрх эзэмшигчдийн 21,619,717 ширхэг нэгж эрхийн санал буюу 95.51 хувийн саналаар батлав.

КОМПАНИЙН ТУЗ-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр батлахад өгсөн саналын эрхтэй нэгж эрх эзэмшигчдийн 22,505,815 ширхэг нэгж эрхийн санал буюу 97.12 хувийн саналаар ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлав.

Тооллогын комиссын дарга Г.Баасанбат: Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй нэгж эрх эзэмшигчдийн хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг хааж Сангийн менежер Г.Ганзориг хаалтыг үгийг хэлснээр 19 цаг 50 минутад хурал өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨХСӨН:



Хурлын дарга